



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 22 (159)

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг:

- *Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай*
- *Зарилт шүүхийн шүүгчийг томилох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

**Улаанбаатар хот
2000 он**



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны зургадугаар сарын 14 № 22 (159)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

240. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 80	449
241. Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай	Дугаар 81	450
242. Очирдоржийн Цог-д Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээх тухай	Дугаар 83	450
243. Пүрэвжавын Хоролдоржид Монгол Улсын нисэхийн гавьяат техникч цол хүртээх тухай	Дугаар 84	450
244. Магсарын Цэрэнжамцад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 85	451
245. Рэнцэнгийн Цэдэн-Иштг Монгол Улсын Хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 86	451
246. Доржготовын Цэрэнхандад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай	Дугаар 87	451

Хоёр. ЯАМ АГЕНТЛАГИЙН АКТ

247. Журам батлах тухай (Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайдын тушаал)	Дугаар 75	451
248. Журам батлах тухай (Үндэсний татварын ерөнхий газрын даргын тушаал)	Дугаар 33	453

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 5 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 80

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг
үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, өөрөө
хүсэлт гаргасан Агвааны Базарсадыг Ховд аймаг
дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан
тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

Өөр шатны шүүхэд шилжин ажиллах
болсонтой холбогдуулан Бямбаагийн
Тунгалагсайханыг Архангай аймаг дахь сум дундын
шүүхийн шүүгчийн, Зундуйн Энхцэцэгийг Дорнод
аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий
шүүгчийн, Дорждэрэмийн Байгалмааг Сүхбаатар

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2000 оны 5 дугаар
сарын 19-ний өдөр****Дугаар 81****Улаанбаатар
хот****Зарим шүүхийн шүүгчийг
томшлох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Бямбаагийн Тунгалагсайханыг Архангай аймгийн шүүхийн шүүгчийн, Янжингийн Бадамсүрэнг Баянхонгор аймгийн шүүхийн шүүгчийн, Зундуйн Энхцэцэгийг Дорнод аймгийн шүүхийн шүүгчийн, Дорждэрэмийн Байгалмааг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгчийн, Нямдоржийн Пүрэвийг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, Хайдавын Цэсмааг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн, Доржсүрэнгийн Төвшинтөрийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн,

Раднаасамуугийн Алтанцэцэгийг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Сүхбаатарын Ганчимэгийг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Цогоогийн Одончимэгийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Доржийн Алтанцэцэг, Батчулууны Сосорбарам нарыг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Нямжавын Туяа, Хуягийн Баттулга, Цээлийн Амаржаргал нарыг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Н.БАГАБАНДИ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ****2000 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр****Дугаар 83****Улаанбаатар
хот****Очирдоржийн Цог-д Монгол Улсын
гавьяат нисгэгч цол хүртээх тухай**

Монголын иргэний агаарын тээврийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж ниссэн цаг, зайгаар өндөр амжилтад хүрч, нислэгийн аюулгүй байдлыг ханган, зорчигчид болон ачаа тээвэрлэх, авиа химийн үүрэг гүйцэтгэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Агаарын тээврийн "Хангарьд" ХХК-ийн АН-24 онгоцны дарга Очирдоржийн Цог-д Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Н.БАГАБАНДИ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ****2000 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр****Дугаар 84****Улаанбаатар
хот****Пүрэвжавын Хоролдоржид Монгол
Улсын нисэхийн гавьяат техникч цол
хүртээх тухай**

Монголын иргэний агаарын тээврийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж нисэх онгоцны засвар үйлчилгээний материаллаг баазыг бэхжүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "МИАТ" компанийн Агаарын хөлгийн

засвар үйлчилгээний газрын дарга Пүрэвжавын Хоролдоржид Монгол Улсын нисэхийн гавьяат техникч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 85

Улаанбаатар
хот

**Магсарын Цэрэнжамцад Монгол Улсын
соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх
тухай**

Хэвлэл мэдээллийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж монголын орчин үеийн уран сайхны гэрэл зургийг хөгжүүлэх, гэрэл зургийн ховор нандин өвийг хамгаалах, сэргээн засварлах, гэрэл зураг судлал, үндэсний фото сэтгүүл зүйн хөгжилд оруулж байгаа хувь

нэмрийг нь үнэлж гэрэл зургийн сурвалжлагч, сэтгүүлч Магсарын Цэрэнжамцад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар
хот

**Рэнцэнгийн Цэдэн-Ишт Монгол Улсын
хүний гавьяат эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбарт удаан жил үр бүтээлтэй ажиллаж эмчилгээ, оношлогооны дэвшилтэт аргуудыг бүтээлчээр нэвтрүүлж, олон мянган хүнийг мэс заслын аргаар эмчлэн эдгэрүүлж, хүн ардын эрүүл мэндийг хамгаалах үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Сакура" клиникийн төв эмнэлгийн мэс заслын

тасгийн эрхлэгч, их эмч Рэнцэнгийн Цэдэн-Ишт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 87

Улаанбаатар
хот

**Доржготовын Цэрэнхандад Монгол Улсын
гавьяат тамирчин цол хүртээх тухай**

Бөхийн самбо, жү-до барилдааны төрлөөр дэлхий, тив, олон улсын болон Монгол улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцож, 1999 онд бөхийн самбо барилдааны дэлхийн аварга болж, эх орныхоо нэр алдрыг дуурсгасан гавьяаг нь

үнэлж Их шавийн дээд сургуулийн багш Доржготовын Цэрэнхандад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2000 оны 3 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын "Автотээврийн тухай хууль"-ийн 16 дугаар зүйлийг үндэслэн **ТУШААХ нь:**

сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж хэрэгжүүлэхийг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжав, Автотээврийн газрын дарга П.Ориг нарт даалгасугай.

1. "Тээвэрлэлтийн баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2000 оны 4 дүгээр

САЙД

Г.БАТХҮҮ

ТЭЭВЭРЛЭЛТИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХЭВЛҮҮЛЭХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Автотээврийн хэрэгслээр зорчих тасалбар, ачаа тээвэрлэлтийн дагалдах хуудас зэрэг тээвэрлэлтийн баримт бичгийг хэвлүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Авто тээврийн ажил үйлчилгээг эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүд энэ журамд дурдсан тээвэрлэлтийн баримт бичгийг үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

1.3 Авто тээврийн ажил үйлчилгээнд хэрэглэх тээвэрлэлтийн баримт бичгийг дотор нь үнэт цаас, хяналтын бүртгэл гэж хоёр ангилна.

а. Улс, хот хооронд, орон нутаг, хотын дотор болон хот орчмын нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдод олгох зорчих тасалбар нь үнэт цаасанд тооцогдоно.

б. Автотээврийн үйл ажиллагаанд хөтлөх ба ашиглах ачаа тээвэрлэлтийн дагалдах хуудас, тээвэрлэлтийн ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл /лицензи/, гэрчилгээ, тээвэрлэлтийн бусад баримт бичиг, анхан шатны бүртгэл нь хяналтын бүртгэлд багтана.

1.4 Тээврийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх тээвэрлэлтийн баримт бичгийн загварыг авто тээврийн асуудал эрхэлсэн төв байгууллага /Авто тээврийн газар/ батлана.

Хоёр. Тээвэрлэлтийн баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах

2.1 Тээврийн асуудал эрхэлсэн төв байгууллага нь тээврийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх тээвэрлэлтийн баримт бичгийг нэгдсэн журмаар хэвлүүлж хангана.

2.2 Тээврийн асуудал эрхэлсэн төв байгууллага нь хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагатай тээвэрлэлтийн баримт бичгээр хангах, түүнийг ашиглах талаар харилцан үүрэг хүлээсэн гэрээ байгуулан ажиллана.

2.3 Тээвэрлэлтийн баримт бичгийг хэвлүүлж хангахтай холбогдсон үйлчилгээний

үнэ хөлсийг гэрээгээр тохирно.

2.4 Улс, хот хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын зорчигчдын нийтийн тээврийн зорчих тасалбар нь өөр өөр загвар, дугаартай байна.

2.5 Улс хооронд зорчигчдын тасалбар нь монгол ба тухайн харилцагч орны хэл дээр хэвлэгдсэн байна.

2.6 Улс, хот хооронд, орон нутагт зорчигчдын тасалбарт зорчигчийн овог нэр, тээврийн хөлсний үнэ, явах чиглэл, он, сар, өдөр амь даатгалыг тодорхой бичиж харуулсан байна.

2.7 Улс, хот хооронд, орон нутагт зорчигчдын тасалбарт гурван хувь хуудас байх бөгөөд зорчигчийн тасалбар гэснийг зорчигчдод өгч хорон хувь дээр үлдэх хэсгийг тээвэрлэгч, зуучлагч байгууллага авч тооцоо хийнэ.

2.8 Улс, хот, хооронд орон нутаг, хотын доторхи болон хот орчмын зорчигчдын тасалбарын зааврыг өөрчлөх зайлшгүй шаардлага гарвал тээврийн асуудал эрхэлсэн төв байгууллагад саналаа оруулж шийдвэрлүүлнэ.

2.9 Улс, хот хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын зорчигчдын нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг газруудад үнэт цаас үйлдвэрлэхийг хориглоно.

2.10 Улс, хот хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын зорчигчдын нийтийн тээвэрээр зорчих тасалбарыг үнэт цаас хэвлэх эрх бүхий байгууллагаар хэвлүүлнэ.

2.11 Нийтийн тээвэрээр зорчих тасалбарыг хэвлүүлэх эрх бүхий байгууллага нь үнэт цаас хэвлүүлэх журмыг мөрдөж үйлдвэрлэлтийн явцад өөрийн буюу гэрээт төлөөлөгчийг томилон хяналт тавьж, үрэгдэх, дутагдах, болон алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

2.12 Нийтийн тээвэрээр зорчих тасалбарыг хуурамчаар хийх боломжгүй байхаар хэв загварт тусгасан байна.

2.13 Тээвэрлэгч нь нийтийн тээвэрээр зорчих тасалбарыг бэлэн мөнгөний нэгэн адил үзэж, хариуцсан хүмүүсийн тайлан тооцоог сар тутам хийх бөгөөд зорчих тасалбарыг



үрэгдүүлэх, завшиж ашиглах зөрчил илэрвэл хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

2.14 Нийтийн тээврээр зорчих тасалбарыг хэрэглэгч тээврийн байгууллага нь урьд сард буюу улиралд авсан зорчих тасалбарын ашиглалтын тайланг авто тээврийн асуудал эрхэлсэн төв байгууллагад гаргаж өгч байна.

2.15 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь урьд авсан зорчих тасалбарын тооцоог хийгээгүй тохиолдолд хангагч байгууллага нь зорчих тасалбарыг олгохоос татгалзаж болно. Энэ тохиолдолд гэрээнд заасан хугацаанд зорчих тасалбарыг олгоогүйгээс хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөнө.

2.16 Нийтээр тээврээр зорчих тасалбарыг аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь ямар нэг шалтгаанаар гэмтээж ашиглах боломжгүй болгосон / усанд норсон гал түймэрт орсон/ буюу алдаж үрэгдүүлсэн тохиолдол гарвал 24 цагийн дотор холбогдох байгууллагуудад мэдэгдэж хүчингүй болгох, үндсэн материалуудад тулгуурлаж тооллого хийж, тооцоог хийж байна.

2.17 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь зорчих тасалбарыг он дамжуулан хэрэглэх тохиолдолд тайлан тэнцэлдээ түүний зарцуулалт үлдэгдлийг үнэн зөв тусгаж байна.

2.18 Улс хоорондын ачаа тээвэрлэлтийн дагалдах баримт бичиг нь монгол ба харилцагч тухайн орны хэл дээр хэвлэгдсэн байна.

2.19 Улс хот хоорондын ачаа тээвэрлэлтийн дагалдах баримт бичигт ачаа

илгээгч, тээвэрлэгч, хүлээн авагч байгууллагын нэр, жолоочийн овог нэр, авто машины марк, улсын дугаар, маршрут, ачааны нэр төрөл, жин, ачааг ачих, буулгах, хүргэх хугацааг тодорхой харуулсан байна.

2.20 Тээвэрлэгч байгууллага нь ачаа илгээгч байгууллагаас ачаа тээвэрлэлтийн дагалдах баримт бичгийг хоёр хувь авч хүлээн авагч байгууллагад нэгийг өгч, үлдэх хувийг өөрийн байгууллагад өгч тооцоо хийнэ.

2.21 Ачаа тээвэрлэлтийн дагалдах баримт бичигт ачааг нэр төрөл, тоо хэмжээгээр нь нэг бүрчлэн хүлээж аваад илүүдсэн, дутагдуулсан хэмжээг тодорхойлж явуулахаар тусгасан байна.

2.22 Ачаа тээвэрлэлтийн дагалдах баримт бичигт замын дагуу товчоо буудал, хяналтын пост тэмдэглэл хийж байхаар тусгасан байна.

2.23 Тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл /лицензи/ гэрчилгээ, анхан шатны бүртгэл зэрэг тээвэрлэлтийн бусад баримт бичгийг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох дүрэм, журмын дагуу хөтөлж ашиглана.

2.24 Авто тээврийн ажил үйлчилгээг эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь батлагдсан загварын тээвэрлэлтийн баримт бичгийг мөрдөөгүй тохиолдолд хууль дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ.

2.25 Тээвэрлэлтийн баримт бичгийг хэвлүүлэх, ашиглахад тавих улсын хяналтыг Дэд бүтцийн улсын хяналтын алба, түүний байцаагч гүйцэтгэнэ.

ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2000 оны 2 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дугаар заалт, Сангийн сайдын 1993 оны 62 дугаар тушаалын 3-ын "а" заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч ажиллуулах журмыг хавсралтаар баталсугай

2. Уг журмыг 2000 оны 4 дүгээр сарын 1-нээс мөрдөж ажиллахыг аймаг, дүүрэг, нийслэлийн татварын хэлтэс, газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү журмын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Удирдлага нөөцийн хэлтэс /Ж.Бавуусүрэн/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТЖАРГАЛ



Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2000 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 33 тоот тушаалын хавсралт

ТАТВАРЫН ИТГЭМЖЛЭГДСЭН НЯГТЛАН БОДОГЧ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар, гадаадын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газарт татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч ажиллуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь Татварын албанд бүртгүүлэн шалгалт өгч, зөвшөөрөл авсан байна.

1.3 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч бүхий татвар төлөгчийг найдвартай татвар төлөгчид хамааруулах нэг шалгуур үзүүлэлт болгон авч үзнэ.

1.4 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь татвар төлөгчийн хувьд мөрдөгдөж байгаа татварын хуулиудын хүрээнд татварын ногдлыг үнэн зөв хийж ногдсон татварыг хугацаанд нь төлүүлж хууль зөрчснөөс хүү торгууль хүлээхээс урьдчилан сэргийлэх, татварын хууль зөрчснөөс санхүүгийн алдагдалд орохоос хамгаалах зорилготой ажиллана.

1.5 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь татварын албаны хувьд татварын хуулийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх хуульд заасан хугацаанд татварын төлбөр хийлгэх хууль зөрчсөнөөс хүлээх алдагдлыг багасгах, татварын ногдол хийх арга зүйгээр татвар төлөгчийг хангах зорилготой ажиллана.

1.6 Татварын нэг итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь хэд хэдэн аж ахуйн нэгж, байгууллагын татварын тооцоог баталгаажуулж болно.

Хоёр. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллах ажилтанд зөвшөөрөл олгоход тавих шалгуур

2.1 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллуулах ажилтан нь нягтлан бодох бүртгэл, санхүү эдийн засгийн мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүү төлбөр тооцооны ажлыг ажлын байранд тавигдаж буй шаардлагын хэмжээнд мэддэг, ажлын дадлага туршлагатай, татварын хууль тогтоомжийн талаар татварын албанаас тавьж буй шаардлагад нийцсэн мэдлэгтэй, цаашид тогтвор зурьчилж ажиллах хүсэл

сонирхолтой хүн байна.

2.2 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллуулах ажилтан нь санхүүгийн болон өртгийн бүртгэл, аудит, менежментийн зөвлөгөө өгөх чадвартай, татварын тайланг гаргах, санхүүгийн болон татварын тайлангийн зөрүүг тооцох, татварын ногдол хийх арга зүйг эзэмшсэн байна.

2.3 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь баклавын болон түүнээс дээш боловсролын түвшинтэй байна. Харин мэргэшсэн нягтлан бодогч бол боловсролын түвшингийн шалгуурт хамаарахгүй.

Гурав. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн зөвшөөрөл олгох шалгалт

3.1 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн зөвшөөрөл олгох шалгалт нь татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч болоход шаардлагатай мэдлэгтэй эсэх, түүнийг хэрэгжүүлэх чадварыг тогтоох зорилготой байна.

3.2 Мэргэжлээрээ ажилласан байдал, санхүү бүртгэлийн алдаа дутагдал урьд өмнө гаргаж байсан эсэхийг шалгалтын ксмисс магадлан тогтоож шалгалтанд орох зөвшөөрөл олгоно.

3.3 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллах зөвшөөрөл авах этгээд нь татварын 7 төрлийн хуулиар шалгалт өгнө.

3.4 Шалгалт өгөх хууль нь: Татварын ерөнхий хууль, Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль, Хүн амын орлогын албан татварын хууль, Онцгой албан татварын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль

3.5 Нягтлан бодох бүртгэлийн шалгалт

3.6 Практик дадлагын шалгалт

3.7 Шалгалтын асуулт, дадлагын чадварыг тогтоох төстийн агуулгыг үндэсний татварын ерөнхий газар гаргана.

Дөрөв. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллуулах зөвшөөрөл олгох шалгалтын комисс

4.1 Татварын итгэмжлэгдсэн нягтлан

бодогчоор ажиллуулах зөвшөөрөл олгоход тавигдсан шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоох зорилго бүхий шалгалтын комисс ҮТЕГ-т ажиллана.

4.2 Комиссын бүрэлдэхүүнийг Үндэсний татварын ерөнхий газрын даргын тушаалаар батална.

4.3 Комисс нь татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа эрхлэх шаардлага хангаж буй эсэхийг тодорхойлсон шалгалтыг авч зөвшөөрөл олгох талаархи санал гарган ҮТЕГ-ын даргын тушаалаар шийдвэрлүүлнэ.

Тав. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, хүчингүй болгох

5.1 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад дараах бичиг баримтыг Үндэсний татварын ерөнхий газарт буюу аймгийн татварын хэлтэст ирүүлнэ.

5.1.1 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллахыг хүссэн өргөдөл

5.1.2 Мэргэжлийн дипломын хуулбар

5.1.3 Мэргэшсэн нягтлан бодогч бол мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээний хуулбар

5.1.4 Анкет

5.1.5 Шалгалтанд орохыг зөвшөөрсөн хариуцагч татвар, санхүүгийн байгууллагын тодорхойлолт

5.2 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг шалгалт бүрт 75 хувиас дээш оноо авсан хүнд шалгалт дууссанаас хойш 14 хоногт багтаан ҮТЕГ-ын даргын тушаалаар олгоно.

5.3 Зөвшөөрлийг жил тутам шинэчлэн олгоно.

5.4 Зөвшөөрөл авснаас хойш нэг улирлын дотор үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд тухайн зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.5 Татварын хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдал нь түүний баталгаажуулсан татварын ногдол, тайлантай холбоотой бол зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.6 Хууль тогтоомж зөрчсөн, зөвшөөрлийн хугацаа дууссан, зөвшөөрөл сунгах шалгалтанд тэнцээгүй тохиолдолд ҮТЕГ-ын даргын тушаалаар хүчингүй болгож нийтэд зарлана.

Зургаа. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчдод татварын албаны зүгээс үзүүлэх тусалцаа

6.1 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчдод татварын талаар мэдлэг олгох сургалтын программ гаргаж түүний дагуу сургалтыг оны эхэнд баталсан хуваарийн дагуу явуулж түүнд тэднийг үнэ төлбөргүй сургаж, мэргэшүүлэх арга хэмжээ авна.

6.2 Татварын тайлан тооцоог үнэн зөв хийж, татварын хуулийг хэрэгжүүлэхэд санаачлагатай ажилласан тухайн татвар төлөгчийг татварын зөрчилгүй ажиллах боломжийг бүрдүүлсэн итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг түүний улирлын цалингийн 30 хүртэл хувиар шагнаж урамшуулахаар тухайн татвар төлөгчид тодорхойлно.

Долоо. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн ажиллах нөхцлийг хангах талаар

7.1 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг татвар төлөгчийн хувьд дараах нөхцлөөр хангаж өгнө.

7.1.1 Татварын ногдол хийхэд шаардагдах татвар ногдох орлого болон татвар ногдуулах орлогыг тодорхойлоход шаардлагатай зардлыг нотлох анхан шатны баримтаар цаг тухайд нь хангах:

7.1.2 Татварын төлөлтийн талаархи мэдээллийг татварын нэр төрлөөр нь гарган өгөх:

7.1.3 Татварын ногдуулалт төлөлтийн талаархи программ хангамжийн талаар байнгын мэдээлэлтэй байх боломжоор хангах:

7.1.4 Бүртгэл, санхүү, татварын тайлангийн маягт, шаардлагатай техник хэрэгсэл, хууль тогтоомж, дүрэм, заавар бусад гарын авлага материалаар цаг тухайд нь хангана:

7.1.5 Татварын албанаас тавьсан шаардлагыг цаг тухайд нь хэрэгжүүлэх боломжтой байх:

7.1.6 Гэрээгээр тохиролцсон бусад нөхцлөөр хангах:

7.2 Татварын алба татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг дараах нөхцлөөр хангаж өгнө.

7.2.1 Татварын ногдуулалт хийх талаар арга зүйн тусалцааг үнэ төлбөргүй буюу төлбөртэй авах:

7.2.2 Татварын хууль тогтоомж, аргачлалыг тэргүүн ээлжинд үнэ төлбөргүй буюу төлбөртэй авах:

7.2.3 Тухайн татвар төлөгчийн төлсөн татварын талаархи шаардагдах мэдээллийг гарган өгөх:

7.2.4 Татварын тайланд орсон өөрчлөлтийн

талаар тэргүүн ээлжинд мэдээлэл өгөх:

Найм. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрхлэх үйл ажиллагаа

8.1 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь татвар төлөгчийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн гүйцэтгэнэ.

8.1.1 Татварын ногдлыг татварын төрөл тус бүр дээр хийж хуулиар тогтоосон хугацаанд төлүүлэхээр удирдлагад мэдэгдэх:

8.1.2 Татварын тайлангийн үнэн зөв эсэхийг шалган тогтоож тайланг тогтоосон хугацаанд нь харьяалах татварын албанд тушаалгах

8.1.3 Ногдсон татварыг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хожимдуулсны хүүг тооцон төлүүлэх арга хэмжээг авахуулах,

8.1.4 Хүн амын орлогын албан татварын суутгалын тооцоог орлого татвар тодорхойлох хуудсаар тооцоо хийлгэх ажлыг зохионо.

8.1.5 Татвар төлөгчийн татварын тайланг шалган баталгаажуулж татварын албанд тушаалгана.

8.2 Татварын албаны хувьд татварын итгэмжилсэн нягтлан бодогч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн гүйцэтгэнэ.

8.2.1 Өөрийн баталгаажуулсан татварын тайланг хуульд заасан хугацаанд тухайн татварын албанд тушаалгах:

8.2.2 Татварын баримт бичилтийн журмын дагуу татвар төлөлтийн баримт бичигдэж байгаа эсэхэд хяналт тавьж энэ журмыг мөрдөн ажиллуулна.

8.2.3 Татварын орлогын сар улирлын хуваарийг татвар төлөгчийн санал болгосноор гарган харьцагч татварын албанд хуульд заасан хугацаанд хүргүүлж батлуулан мөрдүүлнэ.

8.2.4 Татварын илүү , дутуу төлөлтийн тооцоог гарган суутган тооцох, буцаан олгох талаархи саналаа тавьж шийдвэрлүүлнэ.

Ес. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн хүлээх үүрэг

9.1 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа мэдэж авсан

нууцыг шалтгаангүйгээр задруулах буюу ашиглаж үл болно.

9.2 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь хүлээлгэсэн итгэл найдварыг хөсөрдүүлэхгүй ажиллах үүрэгтэй.

9.3 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь өөрөө болон татвар төлөгчөөр татвараа буруу тодорхойлох, татвараас зайлсхийх, шудрага бус замаар татвар буцаан авах зөвлөгөө өгөх үйлдэл хийхгүй байх үүрэгтэй.

Арав. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч ажиллуулснаас гарах үүдлийн төлөө үүрэг хүлээхгүй байх нөхцлүүд

10.1 Татварын алба нь татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн хууль зөрчсөн аливаа үйлдлийн төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй

Арван нэг. Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хяналт тавих

11.1 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаанд ажиллуулж байгаа болон итгэмжлэгдсэн зөвшөөрөл өгсөн харьяалах татварын алба тэдгээрийн удирдлага хамтын хяналт тавьж ажиллана.

11.2 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаанд өгөх үнэлэлт дүгнэлтийг хоёр тал тус бүр дараа улирлын эхний сарын 20-ны дотор гарган цаашид ажиллуулах, урамшуулал олгох эсэх талаар харилцан мэдээлэл солилцоно.

11.3 Татварын алба нь татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаанд түүний баталгаажуулсан татварын тайлан, ногдлыг болон тухайн тайланг шалгах явцдаа хяналт тавина.

11.4 Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчоор ажиллах зөвшөөрөл авсан этгээд үйл ажиллагаагаа эрхэлж байгаа эсэхэд аймаг, дүүрэг, нийслэлийн татварын хэлтэс, газар хяналт тавина.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Илчлэх 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487